



УЛААНБААТАР  
ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ТОГТООЛ

1986 оны 10  
сарын 16 өдөр

Дугаар 222

Улаанбаатар  
хот

Хүүхдийн биеийн тамир,  
спорт, уран бүтээлийн  
төвийг ажиллуулах тухай

83-ны 1986 оны 216-р тогтоолоор хүчингүй

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Зөвлөлтийн барилгын байгууллагын хүчээр орон сууцны III-IV хороололд шинээр баригдсан хүүхдийн биеийн тамир спорт, уран бүтээлийн төвийн барилгыг улсын комиссын актыг үндэслэн хүлээн авч үндсэн хөрөнгөндөө бүртгэн уг барилгын ашиглалт үйлчилгээтэй холбогдсон /талбайн хөлс, халаалт, пахилгаан, хэрэгцээний усны үнэ, засвар үйлчилгээ г.м/ зардлыг хариуцаж ажиллахыг Орон сууц нийтийн аж ахуй удирдах газар /н.Баасанжав/-т даалгасугай.

2. Хорооллын хүүхдүүдэд зориулан чөлөөт цагаар биеийн тамир спорт, урлаг соёлын арга хэмжээ явуулах зориулалттай хүүхдийн биеийн тамир спортын клуб, уран бүтээлийн клуб бүхий төвийг Октябрийн районы АДХ-ын гүйцэтгэх захиргаа, Ардын боловсролын хэлтсийн харьяанд байгуулж түүнд ажиллах дугуйлан, секцийг I хавсралтаар баталсугай.

3. Хүүхдийн биеийн тамир спорт, уран бүтээлийн төвийн түр орон тоог II хавсралтаар баталж цалин хөлс, сургалт аж ахуйн зардлыг Ардын боловсролын төсвийн хийдэгдлээс гаргаж санхүүжүүлэхийг Санхүүгийн хэлтэс /н.Ш.Эрдэмбат/, Ардын боловсролын удирдах газар /н.С.Батмагнай/-т даалгасугай.

4. Хүүхдийн биеийн тамир спорт, уран бүтээлийн төвд ажиллах дугуйлан, секцийг мэргэжлийн багш болон зохион байгуулалт арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ардын боловсролын удирдах газар /н.С.Батмагнай/, Хотын биеийн тамир спортын хороо /н.Содномзундуй/-нд даалгасугай.

5. Хүүхдийн биеийн тамир спорт, уран бүтээлийн төвийн захирал, багш нарт "Ерөнхий боловсролын сургуулийн захирал, хичээлийн эрхлэгч багш нарын цалин олгох, сургалтын ажлын цагийн норм тогтоох тухай" БНМАУ-ын Хөдөлмөр, нийгэм хангамжийн

улсын хороо, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Төв Зөвлөл, Сангийн яам, Ардын боловсролын яамны 1982 оны 63,87,213,291 дүгээр тогтоолд хамруулж, захирлын цалинг бүрэн бус дунд сургуулийн захирлын цалингаар тогтоосугай.

6.Октябрийн районы АДХ-ын гүйцэтгэх захиргаа /н.Мандах/, Хотын ардын боловсролын удирдах газар /н.Батмагнай/-т ДААЛГАХ нь:

а/хүүхдийн биеийн тамир спорт, уран бүтээлийн төвийн санхүү, аж ахуйг Октябрийн районы сургууль, цэцэрлэгийн нэгдсэн аж ахуйн төвд харьяалуулан түүний ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллах;

б/төвийн ажиллах журам, дүрэм, хичээллэх дугуйлан секцийн программыг 10 дугаар сард багтаан боловсруулж мөрдүүлэх.

в/дугуйлан секцүүдэд нэмж шаардагдах зарим мэргэжлээр цагийн багш авч ажиллуулан цалин хөлсийг тогтсон журмын дагуу олгох.

г/орон сууц ашиглалтын байгууллага ОСТ-ны хорооноос хөдөлмөрчдийн дунд явуулах соёл хүмүүжлийн ажилд уг төвийг тусгай графикаар ашиглуулах;

7.Хүүхдийн биеийн тамир спорт, уран бүтээлийн төвд цайны газар гаргаж ажиллуулахыг Нийтийн хоолны удирдах газар /н.Урианхай/-т даалгасугай.

8.Энэ тогтоол гарсантай холбогдуулж Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1986 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 161 дүгээр тогтоолыг хучингүйд тооцсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА С.МӨНХЖАРГАЛ

ХАРИУНЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ч.ЖАМБАЛ

Handwritten signatures in blue ink, including a large signature over the stamp and another signature below it.



Улаанбаатар хотын АЛХ-ын гүй-  
цэтгэх захиргааны 1986 оны  
ЗАХИРГАА дүгээр тогтоолын нэгдүгээр  
хавсралт


ХҮҮХДИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТ, УРАН  
БҮТЭЭЛИЙН ТӨВД АЖИЛЛАХ ДУГУЙЛАН,  
СЕКЦҮҮД

I. Биеийн тамир спортын клуб

- 1. Гимнастикийн дугуйлан
- 2. Гар бөмбөг
- 3. Сагсан бөмбөг
- 4. Ширээний теннис
- 5. Шатар даам
- 6. Чөлөөт бөх

II. Уран бүтээлийн клуб

- 1. Найрал дуу
- 2. Бүжиг
- 3. Фото зураг
- 4. Хатгамал нэхмэл, оёдол
- 5. Хөгжим
- 6. Уран зураг
- 7. Кино техник



Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэт-  
гэх захиргааны 1986 оны  
дугаар тогтоолын хоёрдугаар  
хавсралт

ХҮҮХДИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТ,  
УРАН БҮТЭЭЛИЙН ТӨВИ АЖИЛЛАХ  
ТҮР ОРОН ТОО

- 1.Төвийн захирал
- 2.Төвийн эд хариуцагч, материал бэлтгэгч,  
мөнгөний нярав -2 ✓
- 3.Дежур -6
- 4.Үйлчлэгч /нормативаар/
- 5.Секц, дугуйлангийн багш нар -6